

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЦЭНДИЙН ЭНХСАРУУЛЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
Стратегийн төлөвлөгөөний зорилго 7. "Төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлнэ".							
Зорилт 1 . Биеийн тамир, спорт, соёл урлагийн талаарх хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах							
1.	Арга хэмжээ 1.1 Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр өргөн хүрээтэй зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Хамрагдсан иргэдийн тоо	4900	-	5000	7	11
2.	Арга хэмжээ 1.2 "Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлтийн арга хэмжээнд иргэдийг идэвхтэй оролцуулна.	Хамрагдсан иргэдийн тоо	6700	6800	-	5	5
3.	Арга хэмжээ 1.3 Автомашингүй өдөр нэгдсэн арга хэмжээнд иргэдийг идэвхтэй оролцуулна.	Хамрагдсан иргэдийн тоо	300	-	350	9	9
4.	Арга хэмжээ 1.4 "Дээлтэй Монгол наадам-2024" арга хэмжээнд оролцоно.	Хамрагдсан иргэдийн тоо	700	-	500	7	7
5.	Арга хэмжээ 1.5 Өвлийн спортын арга хэмжээг зохион байгуулна.	Хамрагдсан хүний тоо	1153	1100	-	01	3
6.	Арга хэмжээ 1.6 Д.Лувсаншаравын нэрэмжит Найрал дууны уралдаан зохион байгуулна.	Хамрагдсан сурагчдын тоо	750	-	800	9	10

7.	Арга хэмжээ 1.7 Төрийн байгууллагуудын дунд "Хамтдаа хэвшүүл" арга хэмжээг зохион байгуулна.	Хамруулах байгууллагын тоо	51	52	-	01	3
8.	Арга хэмжээ 1.8 Дүүргийн Засаг даргын нэрэмжит спортын тэмцээнийг 5-с доошгүй төрлөөр зохион явуулна.	Хамрагдсан хүний тоо	680	700	-	4	5
9.	Арга хэмжээ 1.9 "Хамтдаа алхаад эрүүлж" явган алхалтын арга хэмжээг зохион байгуулна.	Хамрагдсан байгууллагын тоо	41	25	45	3	9
Стратегийн зорилго 1. Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшинэ.							
Зорилт 2. Биеийн тамир, спорт, соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих							
1.	Арга хэмжээ 2.1 Дүүргийн хүүхэд, залуучуудыг авьяас хөгжүүлэх олон талт сургалтад хамруулна.	Хамрагдсан хүүхдийн тоо	139	70	150	01	12
2.	Арга хэмжээ 2.2 Хотын соёлт иргэнийг төлөвшүүлэхэд бүх шатны боловсролын байгууллагуудыг хамарсан төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	100%	50%	50%	01	12
3.	Арга хэмжээ 2.3 Соёлын биет өвийг сэргээн засварлах, хамгаалах, хөгжүүлэх болон өвлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулна.	Хэрэгжилтийн хувь	100%	40%	60%	01	12
4.	Арга хэмжээ 2.4 Соёлын биет бус өвийг хамгаалах, хөгжүүлэх болон өвлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулна.	Хамруулсан иргэний тоо	420	200	450	01	12
5.	Арга хэмжээ 2.5 Залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	75%	50%	100%	01	12
6.	Арга хэмжээ 2.6 Хүүхдэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна. (хүүхдийн баяр, цэцэрлэгийн хүүхдийн уран хөдлөгөөнт гимнастик гэх мэт)	Зохион явуулах арга хэмжээний тоо	2	2	2	01	12
Стратегийн зорилго 6. Байгууллагын дотоод үйл ажиллагаа бүрэн уялдаатай болсон байна.							
Зорилт 3. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх							
1.	Арга хэмжээ 3.1 Албан хэрэг хөтлөлтийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, ERP програмын хэрэглээг хэвшүүлэн	Шийдвэрлэлтийн хувь	100%	100%	100%	01	12

	иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, албан бичгийг хуулийн хугацаанд нь чанартай шийдвэрлэнэ.						
2.	Арга хэмжээ 3.2 Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, баримт бичгийг боловсруулах, зохион байгуулах MNS5140:2011 стандартыг мөрдөн байгууллагын архивт хүлээлгэн өгнө.	Хүлээлгэн өгсөн хадгаламжийн нэгжийн тоо	5	5	-	01	3
3.	Арга хэмжээ 3.3 Ажлын цаг, цаг ашиглалтын зөрчилгүй ажиллана.	Цаг ашиглалтын хувь	100%	100%	100%	01	12
4.	Арга хэмжээ 3.4 Төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан мөрдөж ажиллана.	Хэрэгжилтийн хувь	100%	100%	100%	01	12

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1 Дээд шатны байгууллага болон Засаг даргын Тамгын газар, холбогдох сургалтын байгууллагаас зохион байгуулсан сургалтад идэвхтэй хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо	5	2	3	01	12
2.	Арга хэмжээ 2 Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан дүрэм, журмууд, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг танхим болон цахим хэлбэрээр судална.	Судалсан хууль, дүрмийн тоо	3	2	2	01	12

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)

Ц.ЭНХСАРУУЛ / *МЖ* /

(Нэр, гарын үсэг)

2024 01 08

(Огноо)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

(Албан тушаал)

Р.ЦЭВЭЭНДУЛАМ / /

(Нэр, гарын үсэг)

2024 01 08

(Огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЦЭНДИЙН ЭНХСАРУУЛЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дуусан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Стратегийн төлөвлөгөөний зорилго 7. "Төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлнэ".							
Зорилт 1. Биеийн тамир, спорт, соёл урлагийн талаарх хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах							
1.	Арга хэмжээ 1.1 Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр өргөн хүрээтэй зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Хамрагдсан иргэдийн тоо	4900	5000	Дүүргийн Иргэдийн спортын XII их наадмыг 2024 оны 05 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд 3 үе шаттайгаар явган аялал, олс таталт, сагсан бөмбөг, волейбол, хийн дасгал, аэробик, софт волейбол, ширээний шагайн наадгай, дартс гэсэн спортын 9 төрлөөр байгуулж 24 хорооны нийт 6558 иргэнийг хамруулсан. Иргэдийн спортын XII их наадмын нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд 180 тамирчид оролцож, алтан медаль-3 сагсан бөмбөг (эр), волейбол (эр), дартс (эр), мөнгөн медаль-3 олс таталт (эр, эм), ширээний шагай (эм), хүрэл медаль-2 хийн дасгал, аэробик нийт 8 медалийн болзол хангаж багийн дүнгээр 1 дүгээр байр эзэлсэн.	2024.07.01- 2024.11.30	100%
2.	Арга хэмжээ 1.2 "Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлтийн арга хэмжээнд иргэдийг идэвхтэй оролцуулна.	Хамрагдсан иргэдийн тоо	6700	6800	Нийслэлийн Засаг даргын захирамжаар жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлтийн арга хэмжээ 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан.	2024.05.01- 2024.05.25	98%

					Тус гүйлтийн арга хэмжээнд Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын 1590 гаруй ажилтан, албан хаагч, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллага, хороо, төр хувийн хэвшлийн нийт 113 байгууллагын 6570 гаруй ажилтан, албан хаагч, иргэд хамрагдсан. "Улаанбаатар марафон 2024" өдөрлөгийн арга хэмжээг Улсын драмын эрдмийн театрын урд талбайд 11:00-18:00 цагийн хооронд зохион байгуулж, батлагдсан хөтөлбөрийн дагуу өдөрлөгт оролцогч иргэдэд зориулсан соёл урлагийн арга хэмжээ болон спортын 6 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулсан.		
3.	Арга хэмжээ 1.3 Автомашингүй өдөр нэгдсэн арга хэмжээнд иргэдийг идэвхтэй оролцуулна.	Хамрагдсан иргэдийн тоо	300	350	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хороо, Эрүүл мэндийн төв, Соёлын ордон, Боловсролын хэлтэс, "Нийтлэг үйлчилгээний алба" ОНӨААТҮГ зэрэг байгууллагууд хамтран "Автомашингүй өдөр-2024" арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Улсын драмын эрдмийн театрын өмнөх талбайд зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд бадминтон, гир өргөлт, дартс зэрэг спортын 3 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, 370 гаруй иргэнийг хамруулсан.	2024.09.01-2024.09.30	100%
4.	Арга хэмжээ 1.4 "Дээлтэй Монгол наадам-2024" арга хэмжээнд оролцоно.	Хамрагдсан иргэдийн тоо	700	500	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 18 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулагдаж байгаа "Дээлтэй Монгол наадам-2024" арга хэмжээ Д.Сүхбаатарын талбайд 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдсан. Тус наадамд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн 60, 15 дугаар сургуулийн сурагчид, дүүргийн 18 хорооны төлөөлөл иргэд нийт 600 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр наадмын нэгдсэн жагсаалд оролцсон. Жанжин Д.Сүхбаатарын талбайд "Монгол тоглоом наадгай" сэдвийн хүрээнд гэр тохижуулан гадаад, дотоодын аялагч, жуулчин, иргэдэд монгол ахуй, зан заншил, хувцас	2024.07.05-2024.07.10	100%

					хэрэглэл, тоглоом наадгай зэрэг үндэсний уламжлалыг сурталчилсан.		
5.	Арга хэмжээ 1.5 Өвлийн спортын арга хэмжээг зохион байгуулна.	Хамрагдсан хүний тоо	1153	1100	Зайсангийн аманд амарч чөлөөт цагаа өнгөрүүлж буй хүүхэд залуусын дунд зохион байгуулсан өвлийн арга хэмжээ, байгууллагын цасны баяр, "Эко дүүргийн спортлог иргэн" өдөрлөг зэрэг 3 арга хэмжээнд 250 иргэнийг хамруулсан. 1 цанын бааз, 4 мөсөн гулгуурын талбайд 29,720 иргэд, хүүхэд, залуусыг хичээллүүлсэн.	2024.01.02- 2024.03.01	100%
6.	Арга хэмжээ 1.6 Д.Лувсаншаравын нэрэмжит Найрал дууны уралдаан зохион байгуулна.	Хамрагдсан сурагчдын тоо	750	800	Нийслэлийн Засаг даргын ивээл дор уламжлал болгон зохион байгуулагддаг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншарвын нэрэмжит Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах 30 дахь удаагийн уралдааныг 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 75 дугаар сургуульд зохион байгуулж, Хан-Уул дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн 19 сургуулийн 1,100 гаруй сурагч оролцсон. Тус наадмын 2 дугаар шатны шалгаруулалт 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Соёлын төв өргөөнд зохион байгуулагдаж, тусгай байранд Шинэ Монгол Харумафүжи сургуулийн "Шинэ зууны хүүхдүүд" хамтлаг, Д.Лувсаншаравын нэрэмжит шагналаар Хан-Уул дүүргийн 18 дугаар сургуулийн "Шуранхайн тэнгэр" хамтлаг, Монголын найрал дууны уран бүтээлчдийн холбооны нэрэмжит шагналаар Монгол дахь Канад сургуулийн "Нарны үрс" хамтлаг шалгарсан амжилтыг тус тус үзүүлсэн.	2024.09.01- 2024.10.30	100%
7.	Арга хэмжээ 1.7 Төрийн байгууллагуудын дунд "Хамтдаа хэвшүүлье" арга хэмжээг зохион байгуулна.	Хамруулах байгууллагын тоо	51	52	Монгол Улсад орчин цагийн биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор 3 дахь жилдээ "Хамтдаа хэвшүүлье-2024" аяныг 2 үе шаттай зохион явуулсан. Тус аянд 52 байгууллагын	2024.02.05- 2024.03.07	100%

					давхардсан тоогоор 14,889 ажилтан, албан хаагчид хамрагдсан. 1 дүгээр үе-2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 03 дугаар сарын 07-ны өдрийн хооронд цахимаар ажлын байрандаа дурын дасгал, идэвхтэй хөдөлгөөнийг хамт олноороо хийж хэвшүүлэх, 2 дугаар үе-2024 оны 03 дугаар сарын 23-ны өдөр шүүгчийн шатны шалгаруулалт буюу хаалтын ажиллагаанд байгууллага бүр сарын турш хэвшүүлсэн дасгал хөдөлгөөнөөрөө өрсөлдөж шилдгүүдээ тодруулсан.		
8.	Арга хэмжээ 1.8 Дүүргийн Засаг даргын нэрэмжит спортын тэмцээнийг 5-аас доошгүй төрлөөр зохион явуулна.	Хамрагдсан хүний тоо	680	700	Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр 2025 оны 1 дүгээр улиралд зохион байгуулахаар шийдвэрлэсэн.	2024.04.01-2024.05.01	-
9.	Арга хэмжээ 1.9 "Хамтдаа алхаад эрүүлжье" явган алхалтын арга хэмжээг зохион байгуулна.	Хамрагдсан байгууллагын тоо	41	25	"Хамтдаа алхаад эрүүлжье" явган алхалтын аяны 1 дүгээр ээлжийг 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулж, 19 байгууллага, 22 хорооны 600 гаруй иргэд, ажилтан, албан хаагчид, 2 дугаар ээлжийг 11 дүгээр сарын 01, 02-ны өдрүүдэд зохион байгуулж, 39 цэцэрлэг, 19 сургуулийн 800 гаруй багш, ажилчид хамрагдсан.	2024.03.30-2024.11.10	100%
Стратегийн зорилго 1. Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшинэ.							
Зорилт 2.Биеийн тамир, спорт, соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих							
1.	Арга хэмжээ 2.1 Дүүргийн хүүхэд, залуучуудыг авьяас хөгжүүлэх олон талт сургалтад хамруулна.	Хамрагдсан хүүхдийн тоо	139	70	Соёлын ордны авьяас хөгжүүлэх 6 төрлийн сургалтад нийт 218 хүүхэд хамрагдан хичээллэж байна. Өмнөх жилийнхээс 57 хувиар нэмэгдсэн. Үүнээс насны ангиллаар авч үзвэл: 7-18 насны 213, 18-35 насны 5 суралцагч байна. Эмэгтэй-123, Эрэгтэй-93. Хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхдийг үнэ төлбөргүй хамруулж байна.	2024.01.02-2024.12.02	100%
2.	Арга хэмжээ 2.2 Хотын соёлт иргэнийг төлөвшүүлэхэд бүх шатны	Хэрэгжилтийн хувь	100%	100%	"Хотын соёлд-Бидний оролцоо" цахим контентын уралдааныг 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 03 дугаар сарын 25-ны	2024.01.02-2024.12.02	100%

	боловсролын байгууллагуудыг хамарсан төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ.				өдрүүдэд төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 10-12 дугаар ангийн сурагчид мөн төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын багш, ажилчид, эцэг эхчүүдийн дунд зохион байгуулж, 32 байгууллагын 1,500 гаруй иргэд, сурагчдыг хамруулан 42 бичлэг хүлээн авч Насан туршийн суралцахуйн төвийн фэйсбүүк пэйж хуудсанд байршуулан 86,647 хүний хандалт, 10,566 лайк, 7,768 иргэн коммент, 13,052 иргэн шейр хийж олон нийтэд түгээсэн.		
3.	Арга хэмжээ 2.3 Соёлын биет өвийг сэргээн засварлах, хамгаалах, хөгжүүлэх болон өвлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулна.	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Зайсан толгой дахь "Зөвлөлтийн дайчдын дурсгалын цогцолбор", "Хувьсгалт Монгол" танкны хөшөөний иж бүрэн тохижилт, засварын ажлыг 2024 оны 07-09 дүгээр сард ОХУ-ын Ленинград мужийн Засгийн газрын санхүүжилтээр "Шидэт Орос байшин" ХХК хийж гүйцэтгэсэн. Засгийн газрын 2021 оны 179 дүгээр тогтоолоор Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад орсон Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байх "Туулын Хар түнийн ордны туурь", 11 дүгээр хороонд байх "Богд хааны ногоон ордны цогцолбор", "Богд хааны ногоон ордны өмнөх 2 ширхэг чулуун арслан", Нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд байх "Богд хааны хүрэн ордны зарим байшин" зэрэг түүх, соёлын 4 дурсгалын хадгалалт, хамгаалалтыг гэрээгээр хариуцуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	2024.01.02- 2024.12.02	100%
4.	Арга хэмжээ 2.4 Соёлын биет бус өвийг хамгаалах, хөгжүүлэх болон өвлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулна.	Хамруулсан иргэний тоо	420	200	Богцон дахь соёлын өв, өвийн боловсролыг дэлгэрүүлэх, олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хүрээнд "Урлахуйг өвлөө" уулзалтыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр дүүргийн Насан туршийн суралцахуйн төвд зохион байгуулж, гар урлал сонирхогч 84 иргэнийг хатгамалч, нэхмэлч, даалин урлаач, хайчилбар хийгч зэрэг соёл, уламжлалыг өвлөн уламжлагч харилцан туршлага солилцож, мэдлэг бүтээсэн, өв уламжлал, соёлын биет бус	2024.01.02- 2024.12.02	100%

					өвийг дээдлэн хүндэтгэх ёс заншлыг танилцуулсан. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/616 дугаар захирамжийн дагуу Монголын соёл, шашны зан үйлийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор зохион байгуулагдах "Даншиг наадам-Хүрээ цам" шашин соёлын наадам 2024 оны 8 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Хүй 7 худагт зохион байгуулагдсан. "Даншиг наадам-Хүрээ цам" шашин соёлын наадамд дүүргийн соёлын биет бус өвийг өвлөн тээгч, авьяастнууд 2 өдөр хөтөлбөрийн дагуу оролцон, 1600 гаруй иргэд, жуулчдад өв соёлоо сурталчилсан. "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль 2024 оны 08 дугаар сарын 16-наас 18-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт орших "Тайж хайрхан"-ы бэлд зохион байгуулагдаж Соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд Монгол Улсаас 880 өвлөн уламжлагч, 10 гаруй гадаадын улс орнуудын 150 гаруй төлөөлөл оролцсон. Тус фестивальд соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл, нийслэлийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй Хан-Уул дүүргийн харьяат 3 өвлөн уламжлагчдыг оролцуулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газраас зохион байгуулсан "Бүтээлч хот" сэдэвт уралдааны Бүтээлч дүүрэг, бүтээлч хороо номинацид Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Бүтээлч иргэн номинацид-3 иргэн, Бүтээлч аж ахуй нэгж номинацид-2 аж ахуй нэгжийн материалыг бүрдүүлэн Нийслэлийн Соёл, урлагийн газарт хүргүүлснээс: "Бүтээлч хороо" төрөлд Тэргүүн байр: Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо		
--	--	--	--	--	---	--	--

					"Бүтээлч иргэн" төрөлд Гуравдугаар байр: Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны иргэн, Монгол Улсын гавьяат багш Т.Дунжаа "Бүтээлч байгууллага" төрөлд Гуравдугаар байр: "Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв" УТҮГ "Бүтээлч дүүрэг" төрөлд Гуравдугаар байр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар тус тус шалгарсан амжилтыг үзүүлсэн.		
5.	Арга хэмжээ 2.5 Залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	75%	100%	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/63 дугаар захирамжаар "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэхэд 350.0 сая төгрөг баталсан. Үүнээс: 1 дүгээр зорилтын хүрээнд 1, 2 дугаар зорилтын хүрээнд 1, 3 дугаар зорилтын хүрээнд 1, 4 дүгээр зорилтын хүрээнд 6 нийт 9 төсөл, арга хэмжээг дэмжүүлж 303.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. Төсвийн гүйцэтгэл 85 хувь. Үүнд: 1."Ээж бол ертөнц" төсөл 2. Хан-Уул дүүргийн өсвөрийн шигшээ багийн тамирчдад дэмжлэг үзүүлэх төсөл 3. "Хан-Уул хөл бөмбөгийн клуб"-ын тамирчдад дэмжлэг үзүүлэх төсөл 4.Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны залуучуудын дундах 2 төрлийн тэмцээнд дэмжлэг үзүүлэх төсөл 5.Хөгжөөн дэмжигчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчинд дэмжлэг үзүүлэх төсөл 6.Гамшгийн үеийн бэлэн байдалд сайн дурын ажилтан ажиллуулах төсөл 7.Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах таеквондогийн тэмцээнд оролцох тамирчинд дэмжлэг үзүүлэх төсөл 8.Олон улсын сонсголын бэрхшээлтэй иргэдийн Ази Номхон далайн бүсийн нээлттэй тэмцээнд оролцох сагсан бөмбөгийн тамирчдад дэмжлэг үзүүлэх төсөл 9."TEDxKhanUul" төслүүдийг тус тус хэрэгжүүлсэн.	2024.01.02-2024.12.02	90%

6.	Арга хэмжээ 2.6 Хүүхдэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна. (хүүхдийн баяр, цэцэрлэгийн хүүхдийн уран хөдлөгөөнт гимнастик гэх мэт)	Зохион явуулах арга хэмжээний тоо	2	2	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" хөтөлбөрийн хүрээнд дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, ур чадварыг хөгжүүлэх, гимнастикийн дасгал хөдөлгөөнөөр хичээллэх сонирхлыг өрнүүлэх зорилгоор уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Буянт-Ухаа спорт цогцолборт зохион байгуулж, дүүргийн төрийн болон төрийн бус өмчийг 18 цэцэрлэгийн 600 орчим гимнастикч хүүхдүүд, 150 гаруй багш, 2000 гаруй эцэг, эх, хөгжөөн дэмжигчид оролцсон. Дүүргийн аваргаар шалгарсан 250 дугаар цэцэрлэгийн гимнастикч хүүхдүүд нийслэл, улсын аваргаар шалгарсан амжилтыг үзүүлсэн. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" хөтөлбөрийн хүрээнд "Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн нэгдсэн арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр "Степпе арена"-ийн гадна талбайд зохион байгуулж, 5000 орчим хүүхдүүд гэр бүлийнхээ хамтаар оролцсон. Хүүхдийн нас насны ангилалд хамаарах тоглоом наадгай, соёл урлаг, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, волейболын тэмцээн, шатар, даам, ширээний шагайн тэмцээн зэрэг хүүхэд, багачуудад зориулсан арга хэмжээнүүдийг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.	2024.01.02-2024.12.02	100%
Стратегийн зорилго 6. Байгууллагын дотоод үйл ажиллагаа бүрэн уялдаатай болсон байна.							
Зорилт 3.Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх							
1.	Арга хэмжээ 3.1 Албан хэрэг хөтлөлтийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, ERP програмын хэрэглээг хэвшүүлэн иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, албан бичгийг хуулийн хугацаанд нь чанартай шийдвэрлэнэ.	Шийдвэрлэлтийн хувь	100%	100%	2024 онд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр 109 албан бичиг ирснийг судалж шийдвэрлэсэн. Харилцагч байгууллагууд руу 37 албан бичиг төлөвлөж хүргүүлсэн. Энэ хугацаанд 8 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, иргэнд өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хариуг өгч ажилласан.	2024.01.02-2024.12.02	100%

2.	Арга хэмжээ 3.2 Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, баримт бичгийг боловсруулах, зохион байгуулах MNS5140:2011 стандартыг мөрдөн байгууллагын архивт хүлээлгэн өгнө.	Хүлээлгэн өгсөн хадгаламжийн нэгжийн тоо	5	5	Байгууллагын 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 оны 5 хадгаламжийн нэгжийг архивын стандартын дагуу бүрдүүлж, 2024 оны 1 дүгээр улиралд байгууллагын архивт хүлээлгэн өгсөн.	2024.01.02-2024.03.15	100%
3.	Арга хэмжээ 3.3 Ажлын цаг, цаг ашиглалтын зөрчилгүй ажиллана.	Цаг ашиглалтын хувь	100%	100%	Ажлын цаг ашиглалт зөрчилгүй.	2024.01.02-2024.12.02	100%
4.	Арга хэмжээ 3.4 Төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан мөрдөж ажиллана.	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Ёс зүйн зөрчилгүй ажилласан.	2024.01.02-2024.12.02	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	75%	90%	"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрийн 4 зорилт, 10 арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: 1.Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрийн хүрээнд иргэдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх хандлагыг төлөвшүүлж, сэтгэл зүйн эрүүл мэндэд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, сэтгэл зүйн хямралд өртөх эрсдэлийг бууруулах зорилгоор "Сэтгэл зүйн кабинет"-ийг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс хамтран 2024 оны 02 дугаар сараас 08 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд байгуулсан. Сэтгэл зүйн кабинет байгуулах төслийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох материалыг бүрдүүлэн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "Бадрангуй Мөнх" төвтэй түрээсийн гэрээг байгуулсан.	2024.02.28 2024.12.02	90%

					2.Зэвсэгт хүчний 120 дугаар цэргийн ангид "Жендэрийн мэдээлэл, сургалт"-ын танхим байгуулах төсөл 3.Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн "Камержуулалтын төсөл"-ийг тус тус хэрэгжүүлсэн.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Иргэдэд дүүргийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын талаарх тайланг танилцуулах арга хэмжээг зохион байгуулах	Хамрагдсан иргэдийн тоо	-	200	Иргэдэд дүүргийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын талаарх тайланг танилцуулах арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 23-ны өдөр дүүргийн Игэдэд үйлчлэх төв байрны 9 давхрын хурлын танхимд зохион байгуулж 25 хороодын иргэдийн төлөөлөл 200 иргэнийг хамруулсан.	2024.03.20 2024.03.23	100%
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Мэргэжил бүхэн сайхан аян зохион байгуулах	Хэрэгжилтийн хувь	-	100%	Хан-Уул дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Мэргэжил бүхэн сайхан" аяныг 2024 оны 05 дугаар сарын 10-31-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус аяны зохион байгуулалтын ажилд Боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажилласан.	2024.05.10 2024.05.31	100%
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Дүүрэг, улс, нийслэл, тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон дүүргийн өсвөрийн шигшээ багийн тамирчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Тамирчдын тоо	-	30	Дүүрэг, улс, нийслэл, тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон дүүргийн өсвөрийн шигшээ багийн 35 тамирчин, 4 дасгалжуулагч багшийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Иргэдэд үйлчлэх төв байрны 9 давхрын хурлын танхимд дүүргийн Засаг дарга хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн.	2024.05.20 2024.05.25	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

1.	Арга хэмжээ 1 Дээд шатны байгууллага болон Засаг даргын Тамгын газар, холбогдох сургалтын байгууллагаас зохион байгуулсан сургалтад идэвхтэй хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо	5	2	Шихихутуг их сургуулийн Эрх зүйн эчнээ ангийн 3 дугаар курсын 1 дүгээр хагасыг амжилттай төгссөн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Хөгжлийн бодлогын төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" сэдэвт 16 цагийн сургалт, Удирдлагын академийн "Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт" 16 цагийн сургалт, "Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт", Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран зохион байгуулсан "Цахим хөгжлийг дэмжих хууль, тоон гарын үсгийн хэрэглээ, цахим ур чадварын талаар төрийн албан хаагчдад мэдлэг олгох сургалт", "Өргөдөл гомдлын системийн хэрэглээ" цахим сургалт, "Монгол бичгийн цахим бичвэр"-ийн сургалт, "Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай журам, албан бичгийн стандарт, edoc системийн хөгжүүлэлт" сургалт, Нийслэлийн Соёл, урлагийн газраас зохион байгуулсан "Нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагуудын албан хаагчид болон дүүргүүдийн Тамгын газрын соёл, урлагийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан арга зүйн чадавхжуулах сургалт", "Улаанбаатар хотын соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид, соёлын ажилтнуудыг чадавхжуулах" сургалт, "Нийслэлийн соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдээллийн нэгдсэн сан, программыг танилцуулах" зэрэг 10 сургалтад хамрагдсан.	2024.01.02 2024.12.02	100%
2.	Арга хэмжээ 2 Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан дүрэм, журмууд, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон	Судалсан хууль, дүрмийн тоо	3	2	Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан дүрэм, журмуудыг танхим хэлбэрээр судалсан.	2024.01.02 2024.12.02	100%

хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг танхим болон цахим хэлбэрээр судална.						
---	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)

Ц.ЭНХСАРУУЛ / *Ухл* /

(Нэр, гарын үсэг)

2024 12 02

(Огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
5 дугаар хавсралт

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)

Д/д	Үүрэг даалгавар	Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Р.Цэвээндулам	Хэрэгжилтийн хувь	75 хувь хэрэгжүүлсэн.	90-ээс дээш хувь хэрэгжүүлсэн байна.	2024.02.28	2024.12.02

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН


Ц.ЭНХСАРУУЛ /  /

2024 02 20

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Р.ЦЭВЭЭНДУЛАМ /  /



2024 02 20

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
5 дугаар хавсралт

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)

Д/д	Үүрэг даалгавар	Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Иргэдэд дүүргийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын талаарх тайланг танилцуулах арга хэмжээг зохион байгуулах	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Р.Цэвээндулам	Хамрагдсан иргэдийн тоо	-	200	2024.03.20	2024.03.23

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Ц.ЭНХСАРУУЛ /  /


2024 03 18

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Р.ЦЭВЭЭНДУЛАМ /  /

2024 03 18



НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)

Д/д	Үүрэг даалгавар	Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Мэргэжил бүхэн сайхан аян зохион байгуулах	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Р.Цэвээндулам	Хамрагдсан сурагчдын тоо	-	200	2024.05.10	2024.05.31
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Дүүрэг, улс, нийслэл, тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон дүүргийн өсвөрийн шигшээ багийн тамирчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Р.Цэвээндулам	Хэрэгжилтийн хувь	-	100%	2024.05.20	2024.05.25

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Ц.ЭНХСАРУУЛ /  /

2024 05 07

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Р.ЦЭВЭЭНДУЛАМ /  /



2024 05 07

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЦЭНДИЙН
ЭНХСАРУУЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Нийгмийн хөгжлийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1 Зорилт 1.Биеийн тамир, спорт, соёл урлагийн талаарх хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах					
1.	Арга хэмжээ 1.1.	60	10	70	
2.	Арга хэмжээ 1.2.	60	10	70	
3.	Арга хэмжээ 1.3.	60	10	70	
4.	Арга хэмжээ 1.4.	60	10	70	
5.	Арга хэмжээ 1.5.	60	10	70	
6.	Арга хэмжээ 1.6.	60	10	70	
7.	Арга хэмжээ 1.7.	60	10	70	
8.	Арга хэмжээ 1.8.	-	-	-	
9.	Арга хэмжээ 1.9.	60	10	70	
Зорилт 2 Биеийн тамир, спорт, соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих					
1.	Арга хэмжээ 2.1.	60	10	70	
2.	Арга хэмжээ 2.2.	60	10	70	
3.	Арга хэмжээ 2.3.	60	10	70	
4.	Арга хэмжээ 2.4.	60	10	70	
5.	Арга хэмжээ 2.5.	60	10	70	
6.	Арга хэмжээ 2.6.	60	10	70	
Зорилт 3 Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх					
1.	Арга хэмжээ 3.1.	60	10	70	
2.	Арга хэмжээ 3.2.	60	10	70	
3.	Арга хэмжээ 3.3.	60	10	70	
4.	Арга хэмжээ 3.4.	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.	60	10	70	
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.	60	10	70	
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.	60	10	70	
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.	60	10	70	
Дундаж оноо:				70	

Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1.		15	
2.	Арга хэмжээ 2.		11	
Дундаж оноо			13	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		7	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 70
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 13
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		98

Үнэлгээ өгсөн:

Нийгмийн хөгжлийн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

84
/Ч.АРИУНЖАРГАЛ/

2024.12.02. (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

Нийгмийн хөгжлийн хэлтсийн
мэргэжилтэн

/Ц.ЭНХСАРУУЛ/

2024.12.02. (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн дарга

/Л.ОТГОНБАЯР/

2024.12.13. (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөц, хөрөнгө орлогын мэдүүлэг
хариуцсан ахлах мэргэжилтэн

/Б.САРАНЦАЦРАЛ/

2024.12.13. (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Засаг даргын Тамгын газрын
Даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Төсвийн шууд захирагч



/З.БУЯНТ/

2024.12.13. (огноо)